



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/36

Дэлгэрмөрөн

**Техникийн хяналтын үзлэг, тээврийн
хэрэгслийн албан татвар хураалтын
ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, "Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/173 дугаар захирамжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Тээврийн хяналтын үзлэг, албан татвар хураалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Баярсайхан (Засаг даргын орлогч)

Гишүүдэд:

С.Ганбат (Мал эмнэлгийн Улсын байцаагч)

Б.Мөнхэрдэнэ (Цагдаа)

Ю.Батмөнх (Хөх бүрд 1 дүгээр багийн Засаг дарга)

П.Түвшинтөгс (Норовлин 3 дугаар багийн Засаг дарга)

Б.Батшагай (Цорж 4 дүгээр багийн Засаг дарга)

С.Очирбат (Дэлгэрмөрөн 5 дугаар багийн Засаг дарга)

Б.Содномдаржаа (Газрын даамал)

Нарийн бичгийн дарга: А.Дэлгэрмаа (Татварын Улсын байцаагч)

2.Сумын иргэд, байгууллагын эзэмшилд байгаа бүртгэлтэй автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн зам ашигласны төлбөр хураамжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу 2022 оны 06 дугаар сарын 01-ний дотор хураан төсөвт төвлөрүүлж, үр дүнг тайлагнаж ажиллахыг комиссын дарга (Д.Баярсайхан), нарийн бичгийн дарга (А.Дэлгэрмаа) нарт

3.Техникийн хяналтын үзлэгийн үеэр үзлэгт орох тээврийн хэрэгслийг эмх цэгцтэй дарааллын дагуу оруулан хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, цаашид

D /bichig hereg/ Zahiramj -2022 on


642201071

техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байдал, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, орон нутгийн зам ашигласны төлбөр төлөлт, жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсан байдалд бүтэн жилийн турш хяналт шалгалтыг тасралтгүй хийж, зөрчлийг тухай бүр арилгуулахыг Цагдаа (Б.Мөнхэрдэнэ)-д даалгасугай.

4.Өөрсдийн багийн иргэдийг тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт бүрэн хамруулах ажилд идэвх санаачилга гаргаж ажиллахын зэрэгцээ албан татвар хураалт, жолоочийн хариуцлагын даатгал төлөлт, банкуудын гүйлгээ хийгдэх үед ард иргэдийн дунд бөөгнөрөл үүсгэхгүй байх тал дээр анхаарч ажиллахыг багийн Засаг дарга нарт

5.Хүн малын гоц халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ард иргэдэд мэдээлэл өгч, үзлэгийн үеэр ашиглах ажлын байрууд, тээврийн хэрэгсэлд ариутгал халдваргүйжүүлэлт хийж, иргэн бүрийн амны хаалтын хэрэглээнд хяналт тавьж ажиллахыг Сумын эрүүл мэндийн төвийн дарга (М.Дорждагва), Мал эмнэлгийн улсын байцаагч (С.Ганбат) нарт тус тус үүрэг болгосугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Нархүү)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СУМЪЯАБАЗАР